

ДЭЛХИЙД ТАНИГДСАН ЭРДЭМТЭН ХАЙСАНДАЙН 70 НАСНЫ ОЙ ТОХИОЛОО

*Б.Дариа**

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, доктор профессор Л.Хайсандайн 70 насны ойд зориулсан эрдмийн хурал өчигдөр ГХЯ-ны “Зөвшилцөл” танхимд боллоо. ШУА-ийн ерөнхийлөгч, академич Б.Энхтүвшин “Дэлхийд танигдсан эрдэмтэн”, Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын салбарын эрхлэгч, доктор, профессор О.Батсайхан “Монголд Орос судлалыг хөгжүүлэхэд Л.Хайсандайн оруулж буй хувь нэмэр” илтгэлийг тус тус тавьж хэлэлцүүлсэн.

Энэ үеэр гадаадын эрдэм шинжилгээний байгууллагаас ирүүлсэн илгээлтүүдийг уншиж танилцуулсны зэрэгцээ мэргэжил нэгт нөхөд нь үг хэлж цаашдынх нь ажилд амжилт хүслээ. Нөгөөтэйгүүр Ховдоос төрсөн эрдэмтэндээ баяр хүргэхээр нутгийнхан нь иржээ.

ШУА-ийн ерөнхийлөгч, академич Б.Энхтүвшин илтгэлдээ “Л.Хайсандайн эрдмийн бүтээлийн товчооноос харахад эрдэм шинжилгээний ном зохиол 12, хамтын бүтээл найм, өгүүлэл, илтгэл 160 гаруйг нийтлүүлжээ. Үүнээс ОХУ, БНХАУ, БНСУ, Тайвань, Турк, Энэтхэг, Япон зэрэг оронд орос, хятад, англи, испани, солонгос, польш хэлээр хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл 40, хянан тохиолдуулсан ном зохиол 25 зэрэг эрдэм судлалын бүтээлийн жагсаалт хөвөрч түүний цар хүрээ дэлхийд данстай эрдэмтэн болохын нэгээхэн баталгаа гэлтэй. Энэ ч утгаараа Л.Хайсандайн эрдмийн ажил үргэлж дээшилсээр байгаа. Түүний “Монгол Улсын үндэсний эрх ашиг ба гадаад бодлого онол, практикийн асуудал” бүтээл нь Монгол Улсад энэ чиглэлээр судалж туурвисан анхны томоохон бүтээл болсны хувьд хөгжлийн стратеги, түүх, олон улс судлаачдын анхаарлыг зүй ёсоор татдаг. Эл бүтээлийн үнэ цэнийг олон эрдэмтэн онцолсны дотроос түүхийн шинжлэх ухааны доктор Н.Дангаасүрэн, “Монгол Улсын гадаад харилцааг үндэсний эрх ашгийн үүднээс онол, арга зүйн шинэ баримтлал, чиглэлээр судалсанд Л.Хайсандайн бүтээлийн шинэлэг тал. Монгол Улсын үндэсний эрх ашигт багтах харилцан уялдсан асуудлыг онолын хувьд гаргаж тавьсан нь сонирхолтой болжээ” гэж онцолсон байдаг” гэв.

“ҮНЭН”, 2009.12.24, №253

* Б.Дариа - сэтгүүлч